



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/386

Булган сум

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах
өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааг
зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, 2025 оны XII хуралдааны “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2026 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардал батлах тухай” А/97 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг аймгийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлж, зохион байгуулах арга хэмжээний ерөнхий удирдамжийг 1 дүгээр, нэгдсэн төлөвлөгөөг 2 дугаар, шаардагдах төсвийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 17,769,800 (арван долоон сая долоон зуун жаран есөн мянга найман зуу) аймгийн Засаг даргын хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх зардлын Хүүхдийн хөгжил, хамгааллын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлаас, санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

3. Тус үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (О.Ундрах), Булган сумын Засаг дарга (Д.Бямбажаргал) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2026 оны
05 дугаар сарын 27-ны/ний өдрийн
А/386 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ
ӨДРИЙГ УГТАН ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ЕРӨНХИЙ УДИРДАМЖ

Үндэслэл: НҮБ-ын Ерөнхий ассамблей “Хүүхдийн эрхийн тунхаглал”-ыг 1959 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр, “Хүүхдийн эрхийн тухай конвенц”-ыг 1989 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр тус тус баталжээ. Түүнд дэлхийн хамгийн олон буюу 191 орон нэгдэн орсны дотор Монгол Улс 1990 онд 5 дахь орон болон нэгдэн орсон байна. Энэ конвенцын үзэл санаанд нийцүүлэн УИХ-аас “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” хуулийг 1996 онд баталж, 2016 онд хүүхдийн эрхийн тухай хууль шинэчлэн найруулагдаж, Хүүхэд хамгааллын тухай хууль шинээр батлагдсан байна.

Манай аймгийн хувьд нийт 60130 хүн ам оршин суудаг 0-18 насны 21114 хүүхэд багачууд байна. Энэ үзүүлэлтээс харахад нийт хүн амын 35.1 хувийг хүүхэд, өсвөр үеийнхэн эзэлж байна.

Зорилго: Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан, хүүхдийг эрүүл аюулгүй, хамгаалагдсан орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр олон нийтийн санал санаачилгыг өрнүүлж, эрүүл цэвэр орчинд баяр ёслолыг тэмдэглэн өнгөрүүлж, хүүхэд багачуудаа баярлуулах явдал юм.

Хамрах хүрээ, хугацаа: Булган сумын нийт хүүхэд багачуудыг хамруулан 2026 оны 06 дугаар сарын 01-ний 09:00-21:00 цагийн хооронд “Цогт хунтайж”-ийн талбай, “Хүүхэд залуучуудын соёл амралтын хүрээлэн”-д тусгай хөтөлбөрийн дагуу, сум орон нутаг, байгууллагын хэмжээнд өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулна.

Зохион байгуулагчид: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба, Стандарт, хэмжил зүйн хэлтэс, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Биеийн тамир, спортын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Хөгжимт жүжгийн театр, Булган сумын Засаг даргын Тамгын газар, Булган сумын Соёлын ордон, Боловсролын газар, Эрүүл мэндийн газар, “ЭБЦТС” ТӨХК Булган аймаг дахь салбар, Булган сумын тохижилт үйлчилгээний анги.

Зохион байгуулах үйл ажиллагааны чиглэл:

- Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн теле хөтөлбөр бэлтгэж, олон нийтийн сүлжээнд тавих. (ХГБХХГ, АЗДТГ-ын ХМОНХА, ХЖТ, Булган сумын Соёлын ордон)

- Аймаг, сумын Засаг дарга нарыг хамруулан цахим мэндчилгээ бэлтгэн цахимаар түгээх.
- Сум бүр хүүхдийн чуулган, “Хүүхдээ сонсьё” арга хэмжээг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах.
- Нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, нэгдсэн хөтөлбөр гаргах
- Баярын арга хэмжээг зохион байгуулах талбайн зураглал, схем гаргаж, байгууллагуудад тараах.
- Баярын арга хэмжээний нэгдсэн хөтөлбөр гаргаж, постерын эх бэлтгэх.
- Цогт хунтайжийн балбай, Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтыг сайжруулах, хүүхдийн тоглоомын засвар үйлчилгээ, орчны цэвэрлэгээг сайжруулж, чимэглэх.
- Алдарт эхийн одон гардуулах үйл ажиллагаа зохион байгуулах
- 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрийг архигүй, хүүхдийн дэргэд тамхи татахгүй, авто машингүй өдөр байхаар аймгийн Засаг даргын шийдвэр гаргах.
- Байгууллага бүр гадна орчноо цэвэрлэж, чимэглэх.
- **“Хүүхэд эрхэм хэрэглэгч”** Хүүхдийн худалдааны гудамж ажиллуулах, нэгдсэн зохион байгуулалт хийх.
- Баярын арга хэмжээний өглөө 09:00-21:00 цагийн хооронд сумын төвийн зам хаах зохицуулалт хийж, аюулгүй байдлыг хангах.
- Баярын жагсаал (Хүүхдийн оролцоо, Сурлага, урлаг, спорт, дугуйтай, скүтертэй гэх мэт) нийт 500 орчим хүүхэд оролцуулах.
- Хүүхдийн баярын нээлтийн үйл ажиллагаа.
- “Булган хотын шилдэг хүүхдүүд-2026” урлагийн шилдэг хүүхдүүдийн тоглолт зохион байгуулах
- Аймгийн удирдлагын бүрэлдэхүүн зорилтот өрхийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй айл өрхүүдээр орох
- Хүүхдийн жүжиг тоглох (ХЖТ)
- Хүүхдүүдэд зориулсан өртөөчилсэн тэмцээн, уралдаан зохион байгуулах (Цогт хунтайжийн талбай, Соёл амралтын хүрээлэн)
- “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн хаалтын үйл ажиллагаа
- Нэгдсэн арга хэмжээний талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх,

-----oO-----

Аймгийн Засаг даргын 2026 оны
 X/286 дугаар 05 дугаар сарын 27-ны/ний өдрийн
 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



**ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДРИЙГ
 АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ АРГА
 ХЭМЖЭЭНИЙ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ**

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах албан тушаалтан	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
1	2	3	4	5
Нэг. Засвар, чимэглэл, бэлтгэл хангах арга хэмжээ				
1.1	Баярын арга хэмжээний нэгдсэн хөтөлбөр гаргаж, иргэд олон нийтэд хүргэх, боршур хэлбэрээр хэвлэж, тараах	05/25-27	АЗДТГ-ын НБХ, Булган сумын ЗДТГ, ХМОНХА, ХГБХХГ	Б.Мягмарсүрэн Б.Батбагана Э.Эрболд Г.Одончимэг
1.2	Баярын арга хэмжээг зохион байгуулах талбайн зураглал, схем гаргаж, байгууллагуудад хүргүүлэх	05/27-05/29	АЗДТГ-ын, НБХ, СУАЖЗГ	Б.Мягмарсүрэн Д.Бямбажаргал Г.Алдармөнх Г.Одончимэг
1.3	Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтыг сайжруулах, хүүхдийн тоглоомын засвар үйлчилгээ, орчны цэвэрлэгээ хийх, чимэглэх	05/25-30	Булган сумын ЗДТГ, ТУА	Д.Бямбажаргал Ц.Даваадорж
1.4	06 сарын 01-ний өдрийг архигүй, хүүхдийн дэргэд тамхи татахгүй, авто машингүй өдөр болгох аймгийн Засаг даргын шийдвэр гаргуулах, хэрэгжилтийг хангуулах	05/29	Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ, Булган сумын ЗДТГ, ЦГ	Б.Одхүү, Д.Бямбажаргал Б.Эрдэнэбилэг
1.5	Байгууллага бүр гадна орчноо цэвэрлэж, чимэглэх албан бичиг хүргүүлэх	05/29	Булган сумын ЗДТГ-ын НБХ	Төр, төсвийн байгууллага
1.6	Цогт Хунтайжийн талбайг засах, чимэглэх, тайз угсрах, нэгдсэн зураглал гаргаж, баярын уур амьсгал бүрдсэн орчин бий болгох, хаалтын үйл ажиллагааны салют буудуулах	05/29, 05/31, 06/01	ХЖТ, Соёлын ордон Булган сумын ЗДТГ, ОБГ, ХГБХХГ	О.Ууганчимэг Ц.Энхтуяа Д.Бямбажаргал, Н.Хишигдорж Г.Одончимэг
1.7	Худалдаа, үйлчилгээ, хоолны гудамж ажиллуулах, нэгдсэн зохион байгуулалт хийж, хяналт тавих	05/31-06/01	Булган сумын ЗДТГ, СХЗХ	Д.Бямбажаргал Д.Алтаншагай
1.8	Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр 09:00-20:00 цагийн хооронд зам хаах зохицуулалт хийж, арга хэмжээний нээлт, хаалтын үйл ажиллагаанд хамгаалалт гарган хүүхэд, иргэдийн аюулгүй байдлыг хангах, парад алхалтын урд, хойно цагдаагийн машинаар хамгаалалт хийх	05/31-06/01	Цагдаагийн газар	Б.Эрдэнэбилэг
1.9	Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэн, Цогт хунтайжийн талбайд хогийн сав, зөөврийн	05/29, 05/31, 06/01	Булган сумын ЗДТГ, ТУА	Д.Бямбажаргал Ц.Даваадорж

	нойл байршуулж, байнгын ажиллагаатай байлгах			
1.10	Цогт Хунтайжийн талбайд 500 сандал зөөн байршуулж, эзэнжүүлэх	05/29, 06/01	АЗДТГ-ын Нийтлэг үйлчилгээний алба	С.Батнасан
1.11	Баярын үйл ажиллагаанд хэрэглэгдэх тогны эх үүсгүүрийг Цогт хунтайжийн талбай, Хүүхэд, залуучуудын цэцэрлэгт хүрээлэнд байршуулж, аюулгүй байдлыг хангах.	05/29, 05/31, 06/01	“ЭБЦТС” ТӨХК Булган аймаг дахь салбар	Л.Отгонбаяр
1.12	Цогт Хунтайжийн талбайд зураг авхуулах орчин бүрдүүлэх	05/25-06/01	БГ, СУАЖЗГ, Музей	Ц.Цолмонбаатар Н.Мөнхзаяа Т.Бэхтөр ЕБС-ийн Технологийн багш нар
1.13	Цогт Хунтайжийн талбайд Тайз засах, чимэглэх	05/30-05/31	ХЖТ, Соёлын ордон Булган сумын ЗДТГ	Д.Ганцогт Ц.Энхтуяа Д.Бямбажаргал
Баярын жагсаалын бэлтгэл хангах				
1.13	Баярын жагсаалын бэлтгэл хангах	05/25-05/30	ХГБХХГ, СУАЖЗГ ХЖТ, Соёлын ордон	Г.Одончимэг Б.Болортуяа О.Ууганчимэг Ц.Энхтуяа
1.14	Улс аймгийн олимпиад, уралдаан тэмцээнд сурлага, урлагийн амжилт гаргасан хүүхдүүдийг баярын жагсаалд бэлтгэх	05/25-30	БГ	Ц.Цолмонбаатар
1.15	Амьд хөгжим хөтөлбөрийн 90 хүүхдийг хөгжим хэрэгсэлтэй баярын жагсаалд бэлтгэх	05/25-06/01	ХЖТ, Соёлын ордон	О.Ууганчимэг Ц.Энхтуяа
1.16	ЗДТГ-ын дэргэдэх “Хурдан” клубын сурагчдыг дрон, техник хэрэгсэлтэй баярын жагсаалд бэлтгэх	05/25-05/30	Цахим шилжилт үйлчилгээний хэлтэс	Н.Ганцолмон
1.17	Шигшээ багийн тамирчид, үндэсний спортын баг тамирчдыг хувцас, өмсгөлтэй баярын жагсаалд бэлтгэх (волейбол, сагсан бөмбөг, таеквандо, жүдо, буудлага, шагайн харваа, сур харваа г.м)	05/25-06/01	БТСГ	Х.Батхишиг
1.18	Хүүхдийн оролцооны бүлгийн сурагчдыг бэлтгэх (Скаут, Улаан загалмай, СӨУЗ, Өсвөрийн сэргийлэгч, Өсвөрийн эмч, Өсвөрийн парламент г.м)	05/25-06/01	ХГБХХГ БГ	Г.Одончимэг Ц.Цолмонбаатар
1.19	Дугуйтай, скүтертэй хүүхдүүдийг баярын жагсаалд бэлтгэх	05/25-06/01	Булган сумын ЗДТГ	Д.Бямбажаргал З.Батбагана
1.20	Загварын дугуйлангийн сурагчдын үзүүлбэр бэлтгэх, бэлэн байдлыг хангах	05/25-06/01	БГ	Б.Сэрчмаа (Улсын байцаагч)
1.21	Баярын жагсаалын үзүүлбэр үзүүлэх өртөөг хариуцах, шаардлагатай техник хэрэгсэл байршуулах	1-р өртөө Соёл амралтын хүрээлэн (үзүүлбэр)	БГ	Б.Сарангэрэл (1-р Сургуулийн Хөгжмийн багш)
		2-р өртөө		Б.Энхмөрөн

		БТСГазрын урд (үзүүлбэр)		(3-р сургуулийн Хөгжмийн багш)
		3-р өртөө Хойд 4 зам (Сагс, Волейбол үзүүлбэр)		Х.Мөнхтогтох (2-р сургуулийн Хөгжмийн багш)
1.22	Баярын жагсаалын үзүүлбэр бэлтгэх (3 спортын төрөл)	05/25-06/01	БТСГ БГ	Х.Батхишиг Ц.Цолмонбаатар ЕБС-ийн Захирлууд
Хоёр. Сургалт, мэдээлэл, бусад арга хэмжээ				
2.1	Булган сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагууд тус бүр 1 үлгэрийн баатар, хүүхэлдэйн киноны Маскот бэлтгэн баярын үйл ажиллагаанд оролцох албан тоот хүргүүлэх	05/25	АЗДТГ-ын НБХ	Б.Мягмарсүрэн
2.2	Сум бүр хүүхдийн чуулган, "Хүүхдээ сонсьё" арга хэмжээг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах	05/25-05/29	ХГБХХГ	Г.Одончимэг, Сумын Засаг дарга нар
2.3	Алдарт эхийн одон гардуулах үйл ажиллагаа зохион байгуулах	05/25-05/29	АЗДТГ-ын ТЗУХ, ХЖТ, БССО, СХЗХ, БСЗДТГ, ТҮА, ЭМГ, ХГБХХГ, ЦГ	Б.Насанжаргал О.Ууганчимэг, Ц.Энхцэцэг, Д.Алтаншагай, Д.Бямбажаргал
2.4	Аймгийн Засаг даргын мэндчилгээг бэлтгэн цахимаар түгээх	05/28-30	АЗДТГ-ын ХМОНХА	Э.Эрболд
2.5	Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн теле хөтөлбөр бэлтгэн хүргэх	05/31	ХГБХХГ, ХЖТ, АЗДТГ-ын ХМОНХА	Г.Одончимэг, О.Ууганчимэг, Э.Эрболд
2.6	Аймгийн удирдлагын бүрэлдэхүүн зорилтот өрхийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй айл ерхүүдээр орох	05/31	ХХУГ, ХГБХХГ	Н.Батжаргал Г.Одончимэг
2.7	Хүүхдийн эрхийг хамгаалах, эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, эцэг эх, асран хамгаалагч, байгууллага, аж ахуй нэгжийн хүлээх үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр контент, шторк, зөвлөмж бэлтгэн олон нийтэд хүргэх	05/25-06/01	ХГБХХГ	Г.Одончимэг
Гурав. Уралдаан, тэмцээн, соёл урлагийн нэгдсэн үйл ажиллагаа				
3.1	Баярын жагсаал (Хүүхдийн оролцоо, Сурлага, урлаг, спорт, дугуйтай, скүтертэй) нийт 500 орчим хүүхэд оролцуулах	06/01	ХЖТ, СУАЖЗГ, БГ, БТСГ, ХГБХХГ, Булган сумын ЗДТГ, БССО	Д.Ганцогт
3.2	Хүүхдийн баярын нээлтийн үйл ажиллагаа. "Булган хотын шилдэг хүүхдүүд - 2026" урлагийн шилдэг хүүхдүүдийн тоглолт зохион байгуулах	06/01	СУАЖЗГ, ХЖТ, ХГБХХГ, Соёлын ордон	Д.Ганцогт Г.Алдармөнх О.Ууганчимэг Г.Одончимэг Ц.Энхтуяа

3.3	“Унадаг дугуйн” уралдаан зохион байгуулах	06/01	ЦГ, “ЭБЦТС” ТӨХК Булган аймаг дахь салбар, “Хас” банк	Д.Эрдэнэбилэг, Л.Отгонбаяр, Б.Галбадрах
3.4	3-7 насны ангилалд ➤ “Зохиолын баатрууд амилсан нь” маскот зохион байгуулах ➤ “Шаар үлээх” хөгжөөнт тоглоом зохион байгуулах	06/01	АННС, Музей	Т.Мөнгөнтуяа Т.Бэхтөр
3.5	8-11 насны ангилалд ➤ “Би хэлнэ” цахим дууны уралдаан зохион байгуулах ➤ VR виртуал музей үйлчлэх МУГЖ Л.Лхасүрэнгийн зохиол “Пандухайн Паян” хүүхдийн жүжиг	06/01	ХГБХХГ, Музей, ХЖТ	Г.Одончимэг Т.Бэхтөр Д.Ганцогт
3.6	12-18 насны ангилалд ➤ 3x3 Сагсан бөмбөгийн тэмцээн зохион байгуулах ➤ “Би Цол дуудаач” уралдаан ➤ “Мөрөөдлийн дүрүүд” уралдаан ➤ “Бид ангиараа бүжигчид” уралдаан	06/01	БТСГ, СУАЖЗГ, АННС	Х.Батхишиг Г.Алдармөнх Т.Мөнгөнтуяа
3.7	“Шог зураг зурах” үйл ажиллагаа зохион байгуулах	05/25-06/01	БГ, Музей	Ц.Цолмонбаатар Т.Бэхтөр, ЕБС-ийн Технологийн багш нар
3.8	Цогт Хунтайжийн талбайд “Чөлөөт тайз” зохион байгуулах (гитар тоглох)	05/25-06/01	Соёлын ордон	Ц.Энхтуяа
3.9	Хаалтын үйл ажиллагаа “Хөгжмийг хүн бүрд” гадна талбайн тоглолт зохион байгуулж, салют буудуулах	05/25-06/01	Соёлын ордон ОБГ	Ц.Энхтуяа, Н.Хишигдорж
Дөрөв. Гэр бүлийн гишүүдэд зориулсан өртөөнүүд				
4.1	“Миний гэр -аюулгүй орчин” гар зургийн уралдаан зохион байгуулах	05/25-06/01	Булган сумын ЗДТГ	П.Наранчимэг Булган сумын 6 багийн Хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтнууд
4.2	Хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулсан өртөөчилсэн арга хэмжээг Хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулах	06/01	Булган сумын ЗДТГ	Д.Бямбажаргал З.Батбагана

-----oOo-----

Аймгийн Засаг даргын 2026 оны
А/386 05 дугаар сарын 21-ний өдрийн
дугаар захирамжийн 3 дугаар хавсралт



ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ
ӨДРИЙГ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ АРГА
ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ТӨСӨВ

д/д	Шаардагдах зардал	Хэмжих нэгж	Нэгж үнэ	Нийт
1	2	3	4	5
Нэг. Хөгжлийн бэрхшээлтэй болон зорилтот өрхийн хүүхдүүдэд өгөх гарын бэлэг				
1.	Тусгай хэрэгцээт хүүхдүүдэд эргэн хяналт зохион байгуулах	58 ш	50,000	2,900,000
Дүн		60	-	2,900,000
Хоёр. Нэгдсэн арга хэмжээнд шаардлагатай хэрэглэгдэхүүн				
1.	Тайз чимэглэл	1	-	1,028,000
2.	Нээлт, хаалтын үйл ажиллагаа	1	-	3,400,000
3.	Зураг авах, зураг зурах материалууд	-	-	1,225,800
4.	Жагсаалд оролцогч хүүхдүүдийн гарт бариулах шаар	1000	500	500,000
5.	Тэмцээн, уралдаан зохион байгуулахад шаардагдах төсөв	4	-	8,716,000
Дүн				14,869,800
Нийт-17,769,800				

-----oOo-----